



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/487

Булган сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)  
Б.Урантөгс (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

С.Амар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тоог Эрүүл мэндийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/37, А/38 дугаарын тушаалын дагуу оновчтой боловсруулж, батлуулахыг ажлын хэсэг (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010492